

**“УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ
САНХҮҮЖҮҮЛЭХ ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ
ЭСЭХ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Пунсалмаа нарын 13 гишүүнээс 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан боловч төсөвт өртөг нь хүрэлцэхгүй болсон, хугацаандаа ашиглалтад орохгүй зогссон болон хэрэгжилт удааширсан төслүүдийн шалтгаан, үр дагавар, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг судалж, улсын төсвийн хөрөнгөөр гүйцээн санхүүжүүлэх шаардлагагүй гэж дүгнэсэн төслүүдийг хувьчлах, төр, хувийн хэвшилд шилжүүлэх арга хэмжээг авч, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, мөн төсөвт өртгийн үндэслэлгүй өсөлтийг бууруулах, төлөвлөлт болон шийдвэр гаргалтыг ил тод, өгөгдөлд суурилсан болгох, төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байна.

Тогтоолын төсөл батлагдсанаар төсвийг үр ашигтай, хэмнэлттэйгээр төлөвлөж хэрэгжүүлэх, батлагдсан зураг төсөвгүй, газрын асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх, мөн Улсын Их Хурлын гишүүд улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим санг ашиглаж мэдээллээр хангагдах боломж бүрдэнэ гэж үзсэн байна.

Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг тогтоолын төслийг дэмжиж байгаагаа илэрхийлж, улсын төсвөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг хэд дахин нэмэгдэж, төсөвт ачаалал үүсгэж байгаа үндсэн шалтгаан болон Улсын Их Хурлын гишүүд төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн санг тогтмол ашиглах боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа магадлалын дүгнэлт гаргаж төсөвт өртгийг нэмэгдүүлж байгаа эрх бүхий байгууллагуудад төрийн аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулах боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар Баянхонгор, Өвөрхангай аймгуудад улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн

төсөвт өртөг нэмэгдэж байгаа шалтгаан болон төсөл, арга хэмжээнүүдийг Төсвийн тухай хуульд тусгагдсан хугацаанд дуусгах боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр, Г.Ганбаатар нар тогтоолын төслийг дэмжиж байгаагаа илэрхийлж, ижил техникийн нөхцөлтэй төсөл, арга хэмжээнүүдийн төсөвт өртгийн дүн зөрүүтэй байгаа үндэслэлийн талаар асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 73.7 хувийн саналаар дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Н.НАРАНБААТАР